

ХЯТАД ХЭМЭЭХ МОНГОЛ НЭРИЙН ТҮҮХЭН ҮНДЭС

Н. АЛТАНТӨГС

Товч агуулга. 13-16-р зууны монгол хэлний сурвалжуудад “Хятад” хэмээх үг “Хятад”, “Хар хятад” гэсэн хоёр хэлбэртэй байна. 13-р зуунд “Хятад” гэдэг үгээр Алтан улсыг, харин “Хар хятад” гэдэг үгээр Хар кидан улс болон Алтан улсын кидан цэргүүдийг багтаан кидан угсаатныг ерөнхийд нь зааж байжээ. “Хятад” нь зөхөн киданы олон тоо төдийгүй, Киданы эзэнт улсын үе буюу түүнээс ч өмнөх үед холбогдох монголчуудаас киданчуудыг нэрлэх оноосон нэр байв. Алтан улс байгуулагдсан үеэс эхлэн тус үгээр Алтан улсыг, харин жинхэнэ киданчуудыг “хар хятад” хэмээх үгээр заах болжээ. Мин улс байгуулагдсаны дараа монгол сурвалжуудад Мин улсыг “Хятад” хэмээн нэрлэж эхэлсэн бөгөөд ингэснээр тус нэр хоёр дахь удаа утга шилжин өөрчлөгдөж, “хятад” гэдэг үгээр хань угсаатны төр улс, газар нутаг, хүн ам, хэл соёлыг заадаг өнөөгийн утга анх бүрэлдэн тогтжээ.

Түлхүүр үг. Монголын түүх, экзоним, Хятан, Хятад, Хар хятад, Алтан улс

Keywords. Mongolian history, exonym, Khitan, Kitad, Kara Khitay, Jin state

Нэр шилжих үзэгдэл

Аливаа угсаатан, үндэстэн-улсын оноосон нэрийн гарал үүсэл, учир шалтгаан түүхийн судалгааны чухал сэдэв байсаар ирсэн. Тодорхой нэг угсаатны нийтлэгийг хөрш зэргэлдээ буюу алс холын бусад ард түмнүүд нэрлэдэг нэр, түүний түүхэн үндэс нь тэдгээр ард түмний төр улсын ба нийгэм-соёлын харилцаа, ертөнцийг үзэх үзэл, төр улсын албан ёсны үзэл суртлыг ч илэрхийлэх удаа бий. Ялангуяа дэлхийн хуурай газрын хамгийн том эзэнт улсыг байгуулж, Евразийн ард түмнүүдийн түүхийг нэгэн үе тодорхойлсон Монголын эзэнт гүрний албан ёсны монгол хэлээр бусад угсаа соёлын нийтлэгүүдийг, бусад төр улсуудыг, эзлэн авсан газар нутаг, хүн амыг хэрхэн нэрлэж байсан нь чухал ач холбогдолтой сэдэв юм.

Монголын өмнөд хөрш, эртний түүхтэй Хятад улс, түүний хүн ам, хэл, соёл, газар нутгийг дэлхийн олон хэлэнд янз бүрээр нэрлэдэг. Орос ба славян хэлний *китай*, перс, араб хэлэнд тархсан *катай* нь *кидан* гэдэг үгнээс гаралтай бол *sina* болон түүнтэй ойролцоо дуудлага бүхий *china*, *hina* зэрэг нэрс баруун зүгийн олон хэлэнд дэлгэрч, харин Зүүн Ази тивд *zhongguo* хэмээх нэрээс гаралтай *chūgoku*, *jungguk* зэрэг хувилбарууд зонхилдог.

Монголчуудын хувьд Хятадыг өнөө үед *хятад*, *нанхиад*, *хужсаа*, *жунгаа* гэх мэт олон янзаар нэрлэдгээс хамгийн түгээмэл нь “*хятад*” хэмээх нэр юм. Энэ үг орчин үеийн 中国 буюу “Дундад улс” гэсэн ухагдахууныг заадаггүй бөгөөд харин түүний голлох угсаатан болох *хань угсаатныг* заана. Иймээс монголчууд Хятадын түүх гэдэгт *хань угсаатны* байгуулсан төр улсын түүхийг, хятад газар гэдэгт *хань угсаатан* оршин сууж ирсэн газрыг л ойлгодог. Энэ ойлголт нь дэлхийн бусад ард түмний Хятадын тухай ойлголтын хамрах хүрээнээс өөр бөгөөд хятадын талаарх монголчуудын ойлголт бусад ард түмнээс илүү нарийвчлалтай байдаг.

Нанхиад, *хужсаа*, *жунгаа* зэрэг бусад нэрсийн утга ерөнхийдөө тодорхой бөгөөд дэлхийн бусад хэлэнд *хятадыг* нэрлэдэг үгийн гарал бас ихэнх тохиолдолд нилээн ойлгомжтой байдаг. Гэвч бидэнд *хятад* гэдэг нэршлийн тухай зарим асуудал тодорхойгүй байна. *Кидан*, *хятад* хоёр нэг үг мөн үү? Хэрэв мөн бол монголчууд хэзээнээс эхлэн *хань угсаатныг* *киданы* олон тооны үгээр “хятад” гэж нэрлэх болсон бэ?

Кидан хэмээх нэрийн гарал, хэлбэр, өрнөдөд түгсэн дуудлагууд ба түүний утгын талаар харьцангуй тодорхой судалгаанууд байдаг ч монгол хэлэнд яагаад “хятад” хэмээн нэрлэх болсон талаар тун бага анхаарч иржээ. П.Пеллио Дундад Азийн ард түмнүүдээс Хятадыг нэрлэж ирсэн Чин, Табгач, Китай зэрэг нэрсийн хувьслыг тодорхой тэмдэглэж, “хятад” хэмээх үгийг *киданы* олон тоо гэж үзсэн ч монгол нэршлийнх нь хувьд цааш гүнзгийрүүлсэнгүй.¹

Монгол хэлэнд “хятад” бол *киданы* олон тоо гэдэгт ихэнх судлаачид санал нэгддэг боловч энэ саналыг үндэслэлтэй нотолсон тайлбар өнөөг хүртэл хараахан алга. Х.Пэрлээ *кидан* хэмээх үгийг *киданчуудын* өөрийн нэр хэмээн үзсэн бол К.Кэйн *хятаны* их, бага бичгийн шинжилгээгээр *китай* хэмээх үгийн дуудлагыг нарийвчлан судалсан бий.² Ш.Чоймаа Монголын нууц товчоог монгол-кирил бичигт хөрвүүлэхдээ *kitadi* гэдэг галигийг “хятан” болгосон бөгөөд тэрээр *хятад* гэдэг үгийг шууд *кидан* гэж үзсэн бололтой. Гэвч эдгээр судлаач *хятад* хэмээх үгийн талаар ямар нэг санал дэвшүүлээгүй юм.

Тус өгүүллийн зохиогч 2022 онд *хятад* хэмээх нэрийн орчин үеийн утгыг монгол сурвалжид нягталж, энэхүү үгээр «Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршивой» (цаашид Лу. Алтан товч гэж товчилно.) зохиол бичигдэх үед нэгэнт *хань угсаатныг* зааж байсан хэмээн үзсэн боловч чухам хэзээнээс эхлэн өөрчлөгдсөн талаар тодорхой санал дэвшүүлээгүй.³

¹ Pelliot, P. *Notes on Marco Polo*. Paris: Adrien Maisson-neuve, 1959, pp. 216-219

² Kane, K. The Great Central Liao Kitan State – *Journal of Song-Yuan Studies*. Vol. 43. 2013, pp. 27-50

³ Altantugs, N., 현대 몽골인의 중국 인식과 그 역사적 뿌리//동북아시아의 상호인식과 혐오

Энэхүү өгүүллээр монгол хэлний *хятад* хэмээх нэрийн түүхэн үндсийг тодруулахыг зорив. Үүний тулд бид монгол хэлний голлох сурвалжууд дахь “*хятад*” хэмээх үгийг түүвэрлэж, тэдгээрийн утгыг ялгаж, түүхэн өөрчлөлтийг тайлбарлан бичихийг зорив. Монгол хэлний голлох сурвалжууд гэдэгт 13-18-р зууны бичгийн сурвалж, хөшөөний бичээс, толь, захидал зэргийг хамруулсан ба бичгийн сурвалжид «Монголын нууц товчоо», «Цагаан түүх», «Лу. Алтан товч», «Гангын урсгал» зэрэг хэд хэдэн сурвалжийг ашиглав.⁴

Тус өгүүлэлд дэлхийн бусад хэлэнд киданчууд ба хятадуудыг нэрлэх нэрийг авч үзэхгүй ба 20-р зуунд шинээр бий болсон ойлголтуудыг судлахгүй. Мөн түүнчлэн энэ бол түүхийн судалгаа тул хэл шинжлэлийн асуудлуудыг хөндөхийг зориогүй болно.

Дундад зууны үеийн монгол хэлний ойлголт, нэршлүүдийг өнөөгийн ойлголтоор тайлбарлахдаа орчин үеийн монголын түүхийн шинжлэх ухаанд хэрэглэж хэвшсэн Кидан, Алтан улс зэрэг нэршлийг хэрэглэв.

Монголын нууц товчоон дахь “хятад” ба “хар хятад”

Хятад хэмээх үг монгол хэлээр анх тэмдэглэгдсэн нь Монголын Нууц Товчоотой холбогдох ба “хятад” хэмээх үг тус зохиолд нийт 31 удаа гарч байна. Түүврийг Рахевильцийн галиг ба Сумъяабаатарын үсгийн толь тус бүрээр нь, зүйл ба мөрийн дугаарын хамт толилуулбал:

1-р хүснэгт

Монголын нууц товчоон дахь “хятад” хэмээх үгийн түүвэр

Зүйл	Рахевильц		Сумъяабаатар	
	Үг	Мөр	Үг, галигийн сэргээлт	Мөр
53	kitad-un	1108	乞塔敦 ki-ta-dun	53.4
132	kitat	3532	乞塔惕 ki-ta-t(i)	132.6
151	qara-kidad-un	4601	哈刺乞(塔)敦 ha-ra-ki-(ta)-dun	151.4
152	qara-kidat-tur	4612	哈刺乞(塔)惕 ha-ra-ki-(ta)-t(i)	152.3
152	qara-kidad-un	4621	哈刺乞塔敦 ha-ra-ki-ta-tun	152.15
177	qara-kidad-un	5907	哈刺乞(塔)敦 ha-ra-ki-(ta)-dun	177.55
198	qara-kidad-un	7319	哈刺乞塔敦 ha-ra-ki-ta-tun	198.28
247	kitat	9901	乞塔惕 ki-ta-t(i)	247.1

(동북아다이멘션 연구총서 09), 경인문화사: 2022. (Алтантөгс, Н. Орчин үеийн монголчуудын хятадыг үзэх үзэл, түүний түүхэн үндэс – Зүүн хойд Азийн харилцан ойлголцол болон дургүйцэл. Кёнин мүнхваса, 2022, солонгос хэлээр)

⁴ Rachewiltz, Igor de. *Index to The Secret History of the Mongols*. Bloomington: Indiana University Publications, 1972; Сумъяабаатар, Б. *Монголын Нууц Товчоо, үсгийн галиг*. Улаанбаатар, 1990; Tumurtogoo, D. *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI Centuries)*. Taipei, 2006; dobu. *üiyürjin mongyol üsüg-ün durasqaltu bičig-üd*. begejing, 1983; Жанчив, Ё., Бямбацэнд, Ц. *Хуа-и-и-юй толь*. Улаанбаатар, 2003; Арван буянт номын цагаан түүх, Улаанбаатар, 2006; Лувсанвандан, *Алтан товч*, Улаанбаатар, 2006; Жамба, *Асрагч нэртний түүх*, Улаанбаатар, 2006; Гомбожав, *Гангын урсгал*, Улаанбаатар, 2006; Дарма гүүш, *Алтан хүрдэн мянган хигээст*, Улаанбаатар, 2006; Гомбованжил, *Алтан эрих*, Улаанбаатар, 2006.

Хятад хэмээх монгол нэрийн түүхэн үндэс

247	kitad-un	9906	乞塔敦 ki-ta-tun	247.8
247	kitad-i	9909	乞塔的 ki-ta-di	247.12
247	qara-kidad-un	9910	哈刺乞塔敦 ha-ra-ki-ta-tun	247.13
248	qara-kitad-un	9922-9923	哈刺乞塔敦 ha-ra-ki-ta-dun	248.6-248.7
250	kitat	10035	乞塔惕 ki-ta-t(i)	250.1
250	kitat	10102	乞塔惕 ki-ta-t(i)	250.5
251	kitat	10106	乞塔惕 ki-ta-t(i)	251.2
251	kitat	10107	乞塔惕 ki-ta-t(i)	251.4
251	kitad-un	10115	乞塔敦 ki-ta-tun	251.13
251	kitad-i	10119	乞塔的 ki-ta-di	251.18
251	kitat	10119	乞塔惕 ki-ta-t(i)	251.19
263	kitad-un	10821-10822	乞塔敦 ki-ta-tun	263.10
263	kitat	10824	乞塔惕 ki-ta-t(i)	263.13
266	kitat	11015	乞塔惕 ki-ta-t(i)	266.7-266.8
266	kitat	11018	乞塔惕 ki-ta-t(i)	266.12
266	qara-kitat	11019-11020	哈刺乞塔惕 ha-ra-ki-(ta)-t(i)	266.14
271	kitat	11221	乞塔惕 ki-ta-t(i)	271.4
271	kitat	11222	乞塔惕 ki-ta-t(i)	271.6
272	kitat	11226	乞塔惕 ki-ta-t(i)	272.1
272	kitad	11227	乞塔敦 ki-ta-tun	272.2
272	kitat	11231	乞塔惕 ki-ta-t(i)	272.7
272	kitat	11303	乞塔惕 ki-ta-t(i)	272.15
272	kitat	11316	乞塔惕 ki-ta-t(i)	272.33

Ох сурвалж: Rachewiltz, Igor de. *Index to The Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University Publications, 1972; Сумъяабаатар, Б. *Монголын Нууц Товчоо, үсгийн галиг*, Улаанбаатар, 1990.

Рахевильцийн галиг дахь түүврээс үзэхэд хятад гэдгийг *kidad*, *kitad*, *kitat*, *kidat* гэж дөрвөн хэлбэрээр бичсэн байна. Тэдгээрийн давтамжийг авч үзвэл, *kidad* 5 удаа, *kitad* 8 удаа, *kitat* 17 удаа, *kidat* 1 удаа давтагдав. Харин Сумъяабаатарын галигт эдгээр нь *kitat*, *kitad* гэсэн хоёр хэлбэртэй. Гэвч эдгээр хэлбэр нь бидний судалгаанд онц холбогдолгүй ба эдгээр дөрвөн өөр хэлбэрийг нэг үг хэмээн үзэж, тус өгүүлэлд *kitad* хэмээн тэмдэглэх болно.

kitad гэдэг үг МНТ-нд агуулгын хувьд үндсэн хоёр хэлбэртэй байна. Үүнд, 1-рт, дангаар бичигдсэн *kitad* 24 удаа, урдаа “хар” гэдэг тэмдэг нэр авсан *qara-kitad* гэдэг хэлбэрээр долоон удаа гарах ба хоорондоо утгын ялгаатай, хар хятад хэмээх үг нь хятад гэдэг үгээсээ өөр утгаар хэрэглэгджээ. Үүнийг тодорхой нягтлахын тулд хятад болон хар хятад гэдэг үг тус бүрийн утгыг авч үзье.

МНТ дахь “хятад” хэмээх үгийн утга

Хятад хэмээх үг урдаа “хар” гэсэн тэмдэг нэргүй дангаараа орсон 24 тохиолдлын утгыг тодорхойлж ялгахын тулд 2-р хүснэгтийг боловсруулав. Тус хүснэгтэд үг тус бүрийн хам өгүүлбэр, ханз үсэг, хятад хадмалыг хамтатгаж, үүнд Рахевильцийн галигийг “А”, Сумъяабаатарын үсгийн толийн галигийг “Б” хэмээн оруулж, хам өгүүлбэрийг Рахевильцийн галигаар, ханз үсэг, хятад хадмал орчуулгыг Сумъяабаатарын үсгийн толиор тус тус оруулав.

2-р хүснэгт

Хятад хэмээх үгийн хам өгүүлбэр, хадмал орчуулга

Зүйл	А галиг	Б галиг	Хам өгүүлбэр	Ханз	Хадмал
53	kitad-un	ki-ta-dun	ambaqai-qahan-ni bariju kitad-un altan-qahan-na a[b]ču otqui-tur	乞塔敦	契丹的
132	kitat	ki-ta-t(i)	bukui-tur kitat irgen-ü altan-qan tatar-un mejüjin-se'ültu-ten	乞塔惕	契丹
247	kitat	ki-ta-t(i)	247. Te'ün-ü qoyina činggis-qahan qonin jil kitat irgen-tür	乞塔惕	金國
247	kitad-un	ki-ta-tun	kitad-un čeri'üt nekeye ke'en čölke a'ula бүтетеке некейү айиси	乞塔敦	金(國)的
247	kitad-i	ki-ta-di	čerik daručaju kitad-i gödölgejü qara-kidad-un jürčed-ün jüyin-ü erekün omoqun čeri'üd-i daruju čabčiyal-a gürtele	乞塔的	契丹行
250	kitat	ki-ta-t(i)	250. činggis-qahan tere morilaqsan-tur kitat irgen-ü	乞塔惕	契丹
250	kitat	ki-ta-t(i)	mori-laqsan-tur kitat irgen-ü aqutai neretü altan-qan-i else'üljü	乞塔惕	契丹
251	kitat	ki-ta-t(i)	teri'üten olon elčin-iyen kitat irgen-ü aqutai altan-qa'an-a	乞塔惕	契丹
251	kitat	ki-ta-t(i)	jētükdejü činggis-qahan noqai jil kitat-irgen-tür basa morilaba	乞塔惕	契丹
251	kitad-un	ki-ta-tun	amasar-a gürü'esü kitad-un čeri'üt qajar ke'en da'aju ireba	乞塔敦	契丹的
251	kitad-i	ki-ta-di	daruju kitad-i hünji'ü bayitala kiduba kitat čeri'üd-iyen	乞塔的	契丹行
251	kitat	ki-ta-t(i)	daruju kitad-i hünji'ü bayitala kiduba kitat čeri'üd-iyen	乞塔惕	契丹
263	kitad-un	ki-ta-tun	mede'ülün tüsijü ečige-yi inu yalawači-yi abčiraju kitad-un jungdu-balaqasu...	乞塔敦	契丹的
263	kitat	ki-ta-t(i)	tula kitat irgen-i mede'ülün daruqas-lu'a tüsiba	乞塔惕	契丹
266	kitat	ki-ta-t(i)	soyurqal ügürün kitat irgen-eče ese ögüle'e ke'en kitat irgen-ü	乞塔惕	契丹
266	kitat	ki-ta-t(i)	emes-iyen qormai jasa'ulutqun kitat irgen-ü altan-qan-nu	乞塔惕	契丹
271	kitat	ki-ta-t(i)	ečige bidan-u kitat irgen-ü altan-qan-ni dorqut talbilu'a edö'e	乞塔惕	契丹

Хятад хэмээх монгол нэрийн түүхэн үндэс

271	kitat	ki-ta-t(i)	bi kitat irgen-tür morilasu ke'en eyetüjü ile'esü ča'adai-aqa	乞塔惕 契丹
272	kitat	ki-ta-t(i)	272. tulai jil ögödei-qahan kitat irgen-tür morilažu	乞塔惕 契丹
272	kitad	ki-ta-tun	jēbe-yi manglai ileba tedüi kitad-un čeri'üd-i daruju hünji'ü	乞塔敦 契丹的
272	kitat	ki-ta-t(i)	bö'es bö'es tölgečün-e tölgele'ülü'esü kitat irgen-ü qajar usun-u	乞塔惕 契丹
272	kitat	ki-ta-t(i)	asaqtažu bö'es öčirün kitat irgen-ü qajar usun-u ejet qa(n)t qajar	乞塔惕 契丹
272	kitat	ki-ta-t(i)	minu jö[b] ese bolu'asu olon mongqol ulus önečirekün kitat irgen	乞塔惕 契丹

Дээрх хүснэгтэд тулгуурлан МНТ дахь хятад хэмээх нэрийг утгаар нь бүлэглэе.

(а) “хятад” гэдэг үг дангаар бичигдсэн тохиолдлууд

Зүйл Өгүүлбэр	
53	ambaqai-qahan-ni barižu kitad-un altan-qahan-na a[b]ču otqui-tur
247	čerik daručažu kitad-i gödölgejü qara-kidad-un жүрчед-үн жүйин-ү ерекүн омоқун čeri'üd-i daruju čabčiyal-a gürtele
251	daruju kitad-i hünji'ü bayitala kiduba kitat čeri'üd-iyen
263	mede'ülün tüsižü ečige-yi inu yalawači-yi abčiražu kitad-un jungdu-balaqasu...

Дээрх түүвэрт буй “хятадыг хөдөлгөж”, “хятадыг хөнжүү байтал хядав”, “хятад цэргүүдээ”, “хятадын Жүндү балгас” зэрэг тохиолдол нь өгүүлбэрийн хам утгаас үзвэл Алтан улсыг хамгийн ерөнхий утгаар заасан ба Алтан улсын оноосон нэрийг “Хятадын Алтан хаан” гэж зөвхөн хаанд нь хамаатуулан нэрлэж байна. Мөн түүнчлэн 9909 мөрөнд хятад, зүрчид хоёр тусдаа бичигдсэнээс үзэхэд хятад нь зүрчидээс илүү ерөнхий ойлголт байна.

(б) “Хятад иргэн” гэдэг холбоо үгээр бичигдсэн тохиолдлууд

Зүйл Өгүүлбэр	
132	bukui-tur kitat irgen-ü altan-qan tatar-un mejüjin-se'ultu-ten
247	Te'ün-ü qoyina činggis-qahan qonin jil kitat irgen-tür
250	činggis-qahan tere morilaqsan-tur kitat irgen-ü
250	mori-laqsan-tur kitat irgen-ü aqutai neretü altan-qan-i else'üljü
251	teri'üten olon elčün-iyen kitat irgen-ü aqutai altan-qa'an-a jetgükdejü činggis-qahan noqai jil kitat-irgen-tür basa morilaba
263	tula kitat irgen-i mede'ülün daruqas-lu'a tüsiba
266	soyurqal ügürün kitat irgen-eče ese ögüle'e ke'en kitat irgen-ü
266	emes-iyen qormai jasa'ulutqun kitat irgen-ü altan-qan-nu
271	ečige bidan-u kitat irgen-ü altan-qan-ni dorqut talbilu'a edö'e bi kitat irgen-tür morilasu ke'en eyetüjü ile'esü ča'adai-aqa
272	taulai jil ögödei-qahan kitat irgen-tür morilažu

272	bö'es bö'es tölgečin-e tölgele'ülü'esü kitat irgen-ü qajar usun-u
272	asaqtaju bö'es öčirün kitat irgen-ü qajar usun-u ejet qa(n)t qajar
272	minu jö[b] ese bolu'asu olon mongqol ulus önečirekün kitat irgen

Эдгээр мөрөнд “хятад иргэний Алтан хан”, “хятад иргэнд”, “хятад иргэнийг мэдүүлэн”, “хятад иргэний газар усны эзэд” гэх зэргээр Алтан улсын хүн амыг шууд заасан ба гэхдээ зүрчид, кидан, хань-хятад зэрэг ямар нэг угсаа гарлын ялгаваргүйгээр нийтэд нь хамруулсан байна.

(в) “Хятадын цэргүүд” гэдэг холбоо үгээр бичигдсэн тохиолдлууд

Зүйл	Өгүүлбэр
247	kitad-un čeri'üt nekeye ke'en čölke a'ula бүтете ле nekejü ayisi
251	amasar-a gürü'esü kitad-un čeri'üt qajar ke'en da'aju ireba
272	jebe-yi manglai ileba tedüi kitad-un čeri'üd-i daruju hünji'ü

Эдгээр мөрөнд Алтан улсын цэргийг ямар нэг салаа утгагүйгээр шууд “хятадын цэргүүд” гэж бичсэн байна. Иймээс МНТ дахь “хятад” хэмээх үг дангаараа хэрэглэгдсэн нөхцөлд зүрчидийн Алтан улсыг заасан бөгөөд харин Алтан улс гэдэг нэр хэрэглэхгүй байна.

“Хятад” гэдэг үгийг хятад хэл рүү хадмалаар орчуулсан байдал харин нилээн эргэлзээтэй юм. МНТ-ны хятад хадмал орчуулгад “хятад” гэдэг үгийг 22 тохиолдолд 契丹 буюу кидан гэж, зөвхөн хоёр тохиолдолд Алтан улс гэж орчуулсан байна. МНТ-ны 247-р зүйлийн

Te'ün-ü qoyina činggis-qahan qonin jil **kitat irgen-tür morilaba**

kitad-un čeri'üt nekeye ke'en čölke a'ula бүтете ле nekejü ayisi

гэдэг хоёр мөрөнд буй “хятад”, “хятадын” гэдэг үгсийг хятад бичээчид 金國 буюу Алтан улс гэж орчуулжээ. МНТ-ны хадмал орчуулгыг үйлдэгч “Хятад” гэдэг үгийг 契丹 буюу кидан хэмээн ойлгож байсан ч яагаад дээрх хоёр тохиолдолд 金國 буюу Алтан улс хэмээн орчуулсан нь тодорхойгүй. Үүний шалтгаан нь, МНТ зохиогдож байх үед “хятад” гэдэг үг нь монголчуудын хувьд Кидан улс, Алтан улсын аль алинд нь хамаардаг, хятад хүний хувьд ойлгоход төвөгтэй утгыг агуулж байсантай холбоотой байж болох юм. МНТ-ны хятад орчуулагч Алтан улсыг заасан утгатай “хятад” гэдэг үгийг ихэнх тохиолдолд кидан 契丹 хэмээн орчуулсан нь орчуулгын алдаа биш, харин монгол хэлний “хятад” хэмээх үгийг кидантай шууд холбоотой гэж үзсэн хэрэг бололтой.

МНТ дахь “хар хятад” хэмээх үгийн утга

“Хятад” хэмээх үг урдаа “хар” гэдэг тэмдэг нэр авч үүссэн “хар хятад” хэмээх үгийн утгыг хэлэлцье. Үүний тулд доор үзүүлсэн 3-р хүснэгтийг боловсруулсан ба 2-р хүснэгттэй ижил аргачлалаар үйлдэв.

3-р хүснэгт

“Хар хятад” хэмээх үгийн хам өгүүлбэр, хадмал орчуулга

№	А галиг	Б галиг	Хам өгүүлбэр	Ханз	Хадмал
151	qara-kidad-un	ha-ra-ki-(ta)-dun	bitün yorčijū qara-kidad-un gür-qan-tur oduqsan aju’u	哈刺乞(塔) 敦	種(名)的
152	qara-kidat-tur	ha-ra-ki-(ta)-t(i)	yabuyu aqa de’ü-yi baraba qara-kidat-tur ba oroba-gü ulus	哈刺乞(塔) 惕	種(名)
152	qara-kidad-un	ha-ra-ki-ta-tun	čui-müren-e qara- kidad-un gür-qan-tur otba-je tende niken	哈刺乞塔敦	種(名)的
177	qara-kidad-un	ha-ra-ki-(ta)-dun	qara kidad-un gür-qan-tur čui-müren-e sarda’ul-un qajar-a otba-je	哈刺乞(塔) 敦	種(名)的
198	qara-kidad-un	ha-ra-ki-ta-tun	‘ud-i da’arin sarda’ul-un qajar’a čui-müren-e bükün qara-kidad-un	哈刺乞塔敦	種名的
247	qara-kidad-un	ha-ra-ki-ta-tun	čerik daručaju kitad-i gödölgejü qara-kidad-un жүрчед-үн жүйин-ү ерекүн омоқун čeri’üd-i daruju čabčiyal-a gürtelē	哈刺乞塔敦	契丹的
248	qara-kitad-un	ha-ra-ki-ta-dun	irejü bidan-u ekekün omoqun qara-kitad-un жүрчед-үн жүйин-ү еркеит čeri’üd-I daruju büreltele kiduju’ui itegeltü čabčiyal-i ber	哈刺乞塔敦	契丹的
266	qara-kitat	ha-ra-ki-(ta)-t(i)	qara-kitat жүйин ирген ају’ui’je edö’e minu itegelten ina’ut bo’orču	哈刺乞塔惕	種名

Хүснэгтэд тулгуурлан хар хятад хэмээх үгийг утгаар нь нягталвал “Хар хятад” хэмээн Хар кидан улсыг заасан таван үг байна. Үүнд:

Зүйл	Өгүүлбэр
151	bitün yorčijū qara-kidad-un gür-qan-tur oduqsan aju’u
152	yabuyu aqa de’ü-yi baraba qara-kidat-tur ba oroba-gü ulus
152	čui-müren-e qara- kidad-un gür-qan-tur otba-je tende niken
177	qara kidad-un gür-qan-tur čui-müren-e sarda’ul-un qajar-a otba-je
198	‘ud-i da’arin sarda’ul-un qajar’a čui-müren-e bükün qara-kidad-un

Эдгээр мөрөнд “Хар хятадын Гүр хаанд”, “Хар хятадад одов”, “Чүй мөрнөө бүхий Хар хятадын” гэх зэргээр Хар Кидан улсыг тодорхой заан нэрлэжээ. Хадмал орчуулгын хувьд дээрх таван тохиолдолд бүгдийг нь 種名 буюу “нэр” хэмээн тайлбарласан.

Хүснэгтэд Хар Киданыг бус, харин Алтан улсын цэргийн ба хүн амын нэг төрлийг “*хар хятад*” хэмээн нэрлэсэн гурван тохиолдол байна. Үүнд:

Зүйл	Өгүүлбэр
247	čerik daručaju kitad-i gödölgejü qara-kidad-un jürčed-ün jüyin-ü erekün omoqun čeri'üd-i daruju čabčiyal-a gürtelē
248	irejü bidan-u erekün omoqun qara-kitad-un jürčed-ün jüyin-ü erkit čeri'üd-i daruju büreltele kiduju'ui itegeltü čabčiyal-i ber
266	qara-kitat jüyin irgen aju'ui'je edö'e minu itegelten ina'ut bo'orču

247-р зүйлд Цавчаалын төлөөх тулалдааны талаар “*хятадыг* хөдөлгөж *хар хятадын зүрчидийн жүйний* эрэхүн омохун цэргүүдийг дарж” гэж бичсэн бөгөөд энэ мөрөнд буй “*хятадыг* хөдөлгөж” гэсэн үгийн “*хятад*” нь Алтан улсын ерөнхий нэр бол харин *хятадын “хар хятад”, “зүрчид”, “жүйн”* эрэхүн омохун цэргүүд гэж тоочиж буй нь Цавчаалын тулалдаанд Зэв жанжны эсрэг байлдаж буй Алтан улсын гурван төрлийн “эрэхүн омохун” шилдэг цэргийг заасан. Алтан улсын гурван төрлийн шилдэг цэргийн хамгийн эхэнд бичигдсэн “*хар хятад*” цэрэг бол *зүрчид* цэрэг бус, *жүйн* цэрэг ч бус юм. Энэ тохиолдолд “*Хар хятад*” хэмээх үгийн хятад хадмал нь 契丹 буюу *кидан* байна. Мөн 266-р зүйлд “*хар хятад жүйн* иргэн ажуу” хэмээн *хар хятадыг жүйнтэй* хамт тоочсон ба энэхүү “*хар хятад*” гэдэг үгийг хятад хадмал орчуулгад 種名 буюу нэрийн зүйл хэмээн хадсан байна. Киданчуудын өөрсдийгөө нэрлэдэг “*китан*”, “*китай*” нэр, мөн түүнчлэн уйгур хэлээр дамжин перс сурвалжуудад дэлгэрсэн “*катай*”, “*китай*” гэдэг хэлбэр Монголын нууц товчоонд тааралдахгүй байна. Гэтэл 13-р зууны монгол хэлэнд киданчуудыг заах ямар нэг нэр үг байх учиртай. Иймээс “*хар хятад*” цэрэг бол Алтан улс дахь *киданы* морин цэрэг, 266-р зүйлд буй “*хар хятад иргэн*” бол Алтан улс дахь *кидан* угсаатай хүмүүс юм.

МНТ дахь “*хятад*”, “*хар хятад*” хэмээх үгсийн утга, түүний хадмал орчуулгыг нягтлан үзэхэд тус хоёр үгийг зохиогч маш ялгамжтай хэрэглэсэн. Үүнд, “*хятад*” гэдэг үгээр Алтан улсын газар, хүн, төрийг ерөнхийлөн нэрлэж, харин “*хар хятад*” гэдэг үгээр Хар Кидан улс, Алтан улсын *киданы* морин цэрэг зэрэг *кидан* угсаатай хүмүүсийг зааж байна. Үүнээс үзэхэд 13-р зууны эхэн хагас гэхэд монгол хэлнээ киданчуудыг “*хар хятад*”, Алтан улсыг “*хятад*” хэмээн нэгэнт тусгайлан ялгаж нэгэнт хэвшсэн байжээ.

Киданчуудыг “*хар хятад*” хэмээн хар өнгөөр нэрийдсэн явдал нь Алтан улсын дотоодод байсан *киданчуудыг зүрчидээс* ялгаж тусгайлан “*хар*” буюу “*жинхэнэ*” гэж нэрлэсэн байх талтай. *Хар хятад* гэдэг нэршил зөвхөн Алтан улсын дотоод дахь *киданчуудыг* заагаад зогсохгүй, Дундад Азид оршин байсан

Хар Кидан улсыг мөн давхар зааж буй нь МНТ-ны зохиогчийн хувьд төдийгүй, тэр үеийн монголчуудын хувьд *хар хятад* гэдэг үг *кидан* угсаатныг, мөн тэдний ноёдын байгуулсан өөр улсыг ч нэрлэх нэр болж байжээ.

Тэгвэл 13-р зууны монголчууд яагаад Алтан улсыг “*хятад*” гэж нэрлэж байв? Үүний шалтгааныг бид нэр шилжих үзэгдлээр тайлбарлах боломжтой. МНТ-ны зохиогч “*хятад*” гэдэг үгээр зөвхөн Алтан улсыг тусгайлан заасан төдийгүй, түүнийг мөхсөний дараа Алтан улсын хуучин нутаг дэвсгэр дээрх оршин суугчдыг мөн адил *хятад* хэмээн зааж байна. Өөрөөр хэлбэл, “*хятад*” хэмээх үг Алтан улсыг мөхсөн хойно ч монгол хэлэнд хэрэглэгдэж, умард Хятад дахь *хань* угсаатан хүн амын нийтлэг нэр болсон байна. Урьд цагт үүнтэй адил шалтгаанаар Кидан улс мөхсөний дараа монголчуудаас *киданыг* нэрлэдэг “*хятад*” хэмээх нэр Кидан улсыг халан гарч ирсэн Алтан улсыг улируулан заах болж, “*хятад*” гэдэг үгэн дээр нэр шилжих үзэгдэл явагдсан бололтой. Энэ бол онц хачин зүйл огт бус бөгөөд урьд нь Хөх Түрэгийн хаант улсын чулууны бичээсүүд дээр хятадын Тан улсыг “*табгач*” хэмээн бичиж байсан нь нэр шилжих бас нэгэн жишээ бөгөөд табгачийн Юаньвэйн их улсын “*табгач*” хэмээх сянби нэрийг Хөх түрэгүүд Тан улсыг заахдаа шилжүүлэн хэрэглэж байсныг харуулна. Иймээс МНТ-ноос өмнөх үеийн монгол хэлээр яригчид “*хятад*” хэмээх үгээр хөрш монгол хэлт *кидан* аймгийг, тэдний байгуулсан Кидан улсыг, улмаар Кидан улсын эзэлсэн газар нутгийг зааж байсан гэж үзэх бүрэн үндэстэй.

Монголын эзэнт гүрний үеийн “*хятад*” ба “*хар хятад*”

Судрын чуулганд тэмдэглэснээр, *хятад* газрыг нийтэд нь *хятадууд* өөрсдөө *Хан жу жуунту*, монголчууд *Чау кут*, энэтхэгчүүд *Чин*, персүүд *Хитай* хэмээж байв. Харин зүүн өмнө хэсгийг хятадууд *Манзы*, монголчууд *Нангиас* (Nankiyas), энэтхэгчүүд *Маха Чин* буюу *Мачин*, баруун өмнө хэсгийг өөрсдөө *Дайлю*, монголчууд *хар жанг*, энэтхэгчүүд *Кандахр* гэж нэрлэдэг ажээ. Хятадын умард этгээдэд байх *киданчуудыг* монголчууд *Хар Китай* хэмээн ялган нэрлэж байсан ба зүрчидийг киданчууд *Нужи*, монголчууд болон бусад ард түмэн *Жүржэ* хэмээн нэрлэж байжээ.⁵ Судрын чуулганы англи орчуулгад “Cathay” хэмээх үгээр Алтан улсыг, “The Altan Khan of Cathay” гэдэг үгээр Алтан улсыг хааныг, “Cathayan language” гэдэг үгээр хятад хэлийг, “Cathay and Machin” гэдэг үгээр умард ба өмнөд Хятадыг тус тус зааж байна.⁶

Монголын эзэнт гүрний үед “*хятад*” хэмээх нэр үргэлжлэн хэрэглэгдсээр ирэхийн хамт өмнөд Сүн улсыг эзлэн дагуулсантай холбоотойгоор монгол хэлэнд “*нангиас*” гэдэг үг гарч иржээ. Өлзийт хааны бичигт “*нангиас*” гэж гарч байгаа нь газарзүйн утгатай бөгөөд Монголын эзэнт гүрэнд эзлэгдсэн Сүн улсын газрыг заасан бололтой.

⁵ *Ахбар-э Моголан буюу монголчуудын элдэв сонин*, Улаанбаатар, 2018, 64-р тал, 9-р зүүлт.

⁶ *Rashiduddin Fazlullah's Jami'u'l-tawarikh: Compendium of Chronicles, A History of the Mongols*, Harvard University, 1998

25. činggis qaγa:n-u uruγ-u:d döčün tabun od-a:ča inayši-
26. da čimadulčaysan-I edüge:
27. tngri-de ibe:gdeǰü būrin aqa degü: joqilduǰu naran
28. urγuqui **Nangγiyas-un** γaǰar-a:ča abun Talu dalai-dur
29. kürtele ulus barilduǰu jamu:d-iya:n uyaγu:lbai.⁷

Тэгвэл анх зохиогдсон цаг хугацааг нь судлаачид 13-р зуунд холбогдуулан үздэг “Арван буянт номын цагаан түүх” хэмээх монгол сурвалжид *хятад* буюу *хар хятад* хэмээх үг аль аль нь гарахгүй ба зөвхөн “Түгүний *Нангиад* улс” хэмээн “*нангиад*” гэдэг үг гарч байна.⁸

Өлзийт хааны бичиг, Судрын чуулганы мэдээ, Арван буянт номын цагаан түүхээс үзвэл, Монголын эзэнт гүрний үеийн монголчууд умард хятадыг “*хятад*”, Сүн улсын оршин байсан өмнөд хятадыг “*нангиас*”, киданчуудыг хар китай буюу “*хар хятад*” хэмээн нэрлэж байсан нь тодорхой байна. Иймээс Монголын эзэнт гүрний үеийн “*хятад*” хэмээх ойлголт нь зөвхөн умард Хятадад хамаардаг, “*хар хятад*” гэдэг үгээр киданчуудыг заадаг зэрэг нь МНТ-той адил бөгөөд эдгээр нэрсийн утганд томоохон өөрчлөлт ороогүй байжээ.

Нэр шилжих хоёрдугаар үзэгдэл: Мин улсын монгол нэр

Их Юань хэмээх Их Монгол Улс мөхөж, хятадад Мин улс байгуулагдсанаар “*хятад*” хэмээх үгэнд тодорхой хувирал гарч эхэлсэн бололтой. Энэ үеийн монгол хэлний сурвалж ховор боловч бид цөөн хэдэн сурвалжаас “*хятад*” хэмээх үгийг шүүрдэв.

Мин улсын эхэн үе буюу 1389 онд холбогдох *Хуа-и-и-юй толь*д “*kita[t]*” хэмээх үгийг хүн амьтны зүйл хэмээн тайлбарласан.⁹ Мөн толийн “Ажаширид өгсөн зарлиг” хэмээх эхэд (Па-1)

егүүтгэюү. эрт хоёр зуун оны урьд.
монгол, **хятад** өвөрмөц харьтан бүхийд. өмнө умар
ялгууртан аж (=байж) бөгөөтөл. хэр маха **хятадын** хаан
осолдож, монголын хаан бээр муу болсоор.
тэнгэр Да Юань монгол хааныг сонгож. монгол газраа
төрүүлж. олон харьтныг мохоож. өмнөд
газдыг амирлуулаад. хойно хөвгүүн ач нар нь
тэнгэрийн зоригийг даган. өмнөд газдыг амирлуулаад.
өмнөд ба умард гүр улсыг нэгтгэж.
монгол ба **хятад** ялгалгүй нийт авай.¹⁰

⁷ Tumurtogoo, D. *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI Centuries)*, Taipei, 2006, pp. 157

⁸ *Арван буянт номын цагаан түүх*, Улаанбаатар, 2006, 22-р тал.

⁹ Жанчив, Ё. Бямбацэнд, Ц. *Хуа-и-и-юй толь*, Улаанбаатар, 2003. 37-р тал.

¹⁰ Жанчив, Ё. Бямбацэнд, Ц. *Хуа-и-и-юй толь*, Улаанбаатар, 2003. 67-68-р тал.

хэмээн бичсэн дотор “*хятадын* хаан”, “өмнөд газдыг”, “монгол ба *хятад*” гэх мэтээр *хятад* гэдэгт өмнөд газар, түүний хааныг шууд заасан ба энэхүү *хятад* гэдэгт умард ба өмнөд Хятадыг хамтатган хэрэглэсэн бололтой байна.

Мөн толийн “Мянганы ноён Нангиасын заргын бичиг” эхэд “*хятад* дайжив”, “*хятад* лугаа хатгалдаж харив” хэмээн *хань* угсаатныг заан тэмдэглэсэн байна.¹¹

Мөн Мин улсын эхэн үед холбогдох “Уйгуржин бичгийн хичээл” эхэд

ümedü dalan erči qitad edüge: ülü çay¹²

хэмээх мөрөнд “*хятад* эдүгээ” гэсэн үг орсон буй.

Эдгээрээс үзэхэд Юань улс мөхөж, хятадын Мин улс байгуулагдсан үеэс эхлэн монгол хэлнээ Мин улсыг бүхэлд нь “*хятад*” хэмээн нэрлэж эхэлсэн бололтой. Энэ нь өнөөгийн монгол хэлэнд буй “*хятад*” хэмээх үгийн үндсэн утга бий болсон явдал бөгөөд МНТ дахь зөвхөн умард Хятадыг заадаг “*хятад*” гэдэг үгнээс шилжин Цагаан хэрмээс өмнө орших *хань* угсаатны улс, хэл, соёлыг заах ерөнхий нэр, бүх хятадыг заах үг болон хувирчээ. “*Хятад*” хэмээх үг ийнхүү хоёр дахь удаагийн нэр шилжих үзэгдэлд өртжээ.

Сонгодог монгол бичгийн дурсгалууд дахь “хятад” хэмээх нэр

17-р зууны эхэн хагаст зохиогдсон Лу. Алтан товч хэмээх монгол сурвалжид киданыг “*Хар хятад*”, Алтан улсыг “*Хятад*” хэмээсэн нь МНТ-той зөрөөгүй таарч байна. Харин тус сурвалжид Мин улсыг “Хятад улс”, бүх Хятадыг “*Хятадын* зургаан муж”, *хань* угсаатан хүнийг “*хятад*” хэмээн нэрлэсэн ба харин *нанхиад* ба *нангиас* гэдэг үг гарахгүй байна.¹³

1677 онд зохиогдсон гэж үздэг “Асрагч нэртийн түүх” хэмээх монгол сурвалжид Алтан улсыг “*Хятад*”, Мин улсыг “*Хятад улс*” хэмээн нэрлэсэн бол¹⁴ 1725 онд зохиогдсон Гомбожавын “Гангын урсгал” хэмээх монгол сурвалжид Мин улс болон хятад газар, хятад соёл, хятад хувцсыг “*хятад*” хэмээн нэрлэжээ.¹⁵ Тус сурвалжид *нангиад* гэдэг үг нэг удаа “*нангиад* төрийн хувцас” хэмээн гарч байна.¹⁶ Энэхүү “*нангиад*” гэсэн үг нь Монголын эзэнт гүрний үеийн “*нангиас*” гэдэг үг мөн боловч түүнээс олон тооны “-д” дагавраар ялгаатай ба энэ хэлбэрээр өнөөг хүрч иржээ.

1739 онд бичигдсэн Дарма гүүшийн “Алтан хүрдэн мянган хигээст” монгол сурвалжид Алтан улс, Мин улсуудыг “*Хятад*” хэмээн нэрлэхээс гадна “Хятад бэйл”, “Муухятад” зэрэг “*хятад*” гэдэг үг оролцсон монгол хүний нэр олноор гарч байна.¹⁷ 1817 онд бичигдсэн Гомбованжилын “Алтан эрих” сурвалжид

¹¹ Жанчив, Ё. Бямбацэнд, Ц. Хуа-и-и-юй толь, Улаанбаатар, 2003. 77-78-р тал.

¹² Dobu, *üüüürjün tongγol üsüg-ün durasqaltu bičig-üü*, Begejing, 1983, 577

¹³ Лувсанвандан, *Алтан товч*, Улаанбаатар, 2006, 106, 107, 194, 197, 211, 214, 222, 223, 233, 234, 236, 250, 271, 273-р тал.

¹⁴ Жамба, *Асрагч нэртийн түүх*, Улаанбаатар, 2006.

¹⁵ Гомбожав, *Гангын урсгал*, Улаанбаатар, 2006, 14, 17-19-р тал.

¹⁶ Гомбожав, *Гангын урсгал*, Улаанбаатар, 2006, 16-р тал.

¹⁷ Дарма гүүш, *Алтан хүрдэн мянган хигээст*, Улаанбаатар, 2006.

нангиад, хятад хоёр үгийг адил утгаар хольж хэрэглэсэн байна.¹⁸

XX зууны эхэн үед албан бичигт хятад хүнийг “*иргэн*” хэмээн бичиж байв. Тухайлбал, 1914 онд Сайн ноён хан аймгийн нэгэн түшмэдийн бичигт “тэр үест цаг түгшүүртэй Ховд хотноо *иргэчүүд* санаа ангижирч дайсан хөл босгож халхын аймгийн цэрэг анги олныг удаа дараацан мордуулж *иргэн* монголчууд санаа учир харилцан зөрүү болсон цаг” хэмээн тэмдэглэсэн¹⁹ бөгөөд энд гарч буй “*иргэчүүд*”, “*иргэн*” хэмээх нь *хятад* хүнийг зааж байна. Гэвч энэ нь тухайн үеийн албан бичгийн нэршил бөгөөд харин энгийн ярианд “*хятад*” нь түлхүүтэй хэрэглэгдэж байсан бололтой. Мөн түүнчлэн, Манжийн Чин улсыг “*хятад*” хэмээн нэрлэх явдал энгийн ардын дунд байсны улбааг угсаатны зүйн хээрийн шинжилгээний ажлын тайлангуудад тэмдэглэгдсэн XIX-XX зууны эхэн үед холбогдох аман түүхийн мэдээллүүд дам харуулдаг. Ховд аймгийн Мөнххайрхан сумын иргэн Т.Нанзад Манжийн Чин улсын үеийн Дархан бэйсийн хошууны тухай аман мэдээг 1988 онд ярихдаа Манжийн хааныг “Хятадын хаан” хэмээж байна.²⁰ Эдгээрээс үзэхэд, монголчууд Мин улсыг *хятад* хэмээн нэрлэснээс хойш “*хятад*” хэмээх үгийн утга өөрчлөгдөлгүй XX зуунд хүрч иржээ.

Дүгнэлт

Кидан улсыг оршин тогтнож байх үед монгол хэлээр яригчид тэднийг “*хятад*” гэж нэрлэж байжээ. Иймээс “*хятад*” гэдэг үгийн түүхэн гарал нь зөвхөн киданы олон тоо төдийгүй, *мэргэд*, *хэрэйд*, *ойрад* зэрэг үгийн адил киданчуудыг “*хятад*” хэмээн заасан монгол хэлний оноосон нэр юм.

Кидан улсыг мөхөөж, түүний газар нутгийг эзлэн байгуулагдсан Алтан улсын үед монголчууд тэднийг Киданы нэрээр “*хятад*” хэмээн нэр шилжүүлэн нэрлэснээр “*хятад*” хэмээх нэр зүрчидийн Алтан улсыг, түүний эзэлсэн газар нутгийг, харьяат хүн ардыг нэрлэх нэр болж хувирсан байна.

Ийнхүү “*хятад*” гэдэг үгийн утга хувирсны улмаас жинхэнэ кидан угсаатнуудыг зүрчидээс ялгах зорилгоор “*хар хятад*” гэдэг үг үүссэн нь Монголын нууц товчоо, Судрын чуулган, Лу. Алтан товч гэсэн гурван сурвалжид “*хар хятад*”, “*хар китай*” гэж тэмдэглэгдэн үлджээ.

Монголчууд монгол хэлт киданыг “*хар хятад*”, зүрчид хэлт Алтан улсыг “*хятад*” гэж 13-р зууны үе гэхэд нэгэнт ялган нэрлэж хэвшсэн байжээ. Иймээс Монголын эзэнт гүрний үеийн монгол сурвалжид “кидан”, “Алтан улс” гэдэг нэршлүүд хэрэглэгдэж байсангүй.

Их Монгол хэмээх Их Юань улс мөхсөний дараа байгуулагдсан хятадын Мин улсыг монголчууд “*хятад*” хэмээн нэрлэх болсноор монгол хэлний “*хятад*” хэмээх нэр хоёр дахь удаа утга шилжжээ. Энэ үеэс эхлэн “*хятад*” хэмээх үг нь

¹⁸ Гомбованжил, *Алтан эрих*, Улаанбаатар, 2006.

¹⁹ Базардорж, Д. *Ар Монгол дахь “Да Шэн Күй” буюу Даашихүү нүүс*, Улаанбаатар, 2015, 160-р тал.

²⁰ *Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн (1988-1989)*, Х боть, Улаанбаатар, 2011, 15-р тал.

зөвхөн Умард Хятадыг заах төдийгүй, өмнөд, умард бүх хятадыг багтаан Мин улсыг заах утгатай болсон нь тус үгийн өнөөгийн утга бий болсон хэрэг юм.

Монгол нутагт байгуулагдсан төр өмнөд хөрш улсаа тухайн улсынх нь өөрийн нэрээр нэрлэх явдал ямагт ховор байж, харин *хань* угсаатныг эзлэн ноёрхож асан өөрсдийн ойр төрлийн аль аймаг, улсын нэрээр өмнөд хөрш *хань* угсаатны байгуулсан төрийг, түүний газар нутаг, хүн амыг шилжүүлэн нэрлэдэг байжээ. Хятад угсаатны Тан улсыг монгол хэлт сяньбийн Юань Вэйн их улсыг нэрлэх “*табгач*” гэсэн сяньби нэрээр, зүрчидийн Алтан улсыг монгол хэлт киданыг нэрлэх “*хятад*” гэж үгээр, хятад угсаатны Мин улсыг мөн адил “*хятад*” гэдэг нэрээр удаа дараа нэрлэж ирсэн энэ үзэгдэл бол монголчуудын ямар нэг төөрөгдөл, орчуулгын алдаа бус, харин Монгол нутагт оршин байсан төр улсууд Хятадад байгуулагдсан төрийг хэрхэн нэрлэх талаар үе уламжлан баримталж ирсэн төрийн бодлого бололтой.

Abstract

In the Mongolian sources of the 13th to 16th centuries, the term "Kitad" has two distinct variations: "Kitad" and "Qara Kitad." Initially, in 13th-century Mongolian, "Kitad" referred specifically to the Jin state in modern northeastern China. On the other hand, the term "Qara Kitad" specifically referred to the Khitans in Mongolian sources of the 13th century. Both the Qara Khitai dynasty and the Khitan soldiers in the Jin dynasty are referred to same as "Qara Kitad" in these sources. By the mid-13th century, the Mongolian language had established these two distinct names, "Kitad" and "Qara Kitad," to clearly differentiate between the Jin Dynasty and the Khitan ethnos. It is worth noting that while "Kitad" is the plural form of the word "Khitans," it also served as a name used by other Mongols to refer to the Khitans during the existence of the Khitan Empire. Over time, as the Ming Dynasty came to be known as "Kitad," the term "Kitad" in the Mongolian language gradually expanded its meaning to encompass the entirety of Ming China, including its population, ethnicity, language, clothing, and culture.